

Огноо: 2023.04.28

№ 23/  
01

Улаанбаатар

**ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ, ТОЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2023 оны 4 сарын 28-ний өдрийн тооллогын комиссын 23/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бизнес төлөвлөгөө болон компанийн үйл ажиллагааг цаашид хэвийн явуулахад шаардлагатай бусад төсөл төлөвлөгөөг батлан зөвшоорсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Д.МАШБАТ

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2023 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 23/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Камолиддин Талипов
2. Дашзэгвэ Машбат
3. Дугарсүрэн Батсайхан
4. Рустамходжаев Сайдаброр
5. Ариунболд Ариунтуяа
6. Цэвэгсүрэн Сарантуяа

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Сүхбаатар Батбилэг
2. Ховдашхан Мухаме тгалим
3. Раднаабазар Отгонбат

3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг б олгосугай.

**ХУРЛЫН ДАРГА Д.МАШБАТ**



Огноо: 2023.04.28

№ 23/03 .

Улаанбаатар

**НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ  
ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2023 оны 4-р сарын 28-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 23/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тус компани нь ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай хувьцаа эзэмшигч парт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.МАШБАТ

Огноо: 2023.04.28

№ 23/04

Улаанбаатар

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ЗАРДЛЫН ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дахь заалтыг үндэслэн 2023 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 23/02 тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2023-2024 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, үйл ажиллагааны зардалыг энэхүү тогтоолын Хавсралт 01-ээр баталсугай.
2. Батлагдсан төсөвт багтаан ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Д.МАШБАТ



Огноо: 2023.04.28

№ 23/  
05.

Улаанбаатар

**“МОРЬТ ИМПЕКС” ХХК-ТАЙ БАЙГУУЛСАН  
ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭН СУНГАХ ТУХАЙ**

Компанийн 2023 оны 4 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 23/02 дугаар тогтоол, хувьцаа эзэмшигчдээс ээлжит хуралд оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байсан Г.Ганбатын “Морьт Импекс” ХХК-иас авах авлагын дүнг баталгаажуулан түүнтэй байгуулсан гэрээг шинэчлэн байгуулсугай.
2. Гэрээг шинэчлэн хийх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан гэрээний дагуу компанийн өр төлбөрийг барагдуулан ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА **Д.МАШБАТ**

